# НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН

## АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

| Д/д | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Зарцуулах хөрөнгө мян/төг | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжил-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ШҮГЭЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх | Баримтжуулсан байх<br><br>Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)<br><br>Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх. | Жилдээ | - | Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн гарын авлага, тараах материалуудыг Нийслэлийн Засаг захиргааны I, II, III, IV, Va, Vбв, Төр захиргааны цогцолбор байр, Нийслэлийн үйлчилгээний Нэгдсэн төв Мишээл, Драгон, Дүнжингарав салбар, Сэлбэ Баянхошуу дэд төвүүдийн нийт 12 байрны мэдээллийн самбарт, Байгууллагын www.khangardi.mn сайт, Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын фэйсбүүк хуудсанд АТГ-аас гаргасан шторк бичлэгийг тогтмол байршуулан ажиллалаа. Тайлант хугацаанд:<br>1. Авлигын эсрэг нэгдье шторк<br>2. Үгүй гэж хэлээд өөрчилье. Авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх утас #110 шторк | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас үйлчилгээ авахад олон нийтэд тулгарч байсан хүнд суртлыг арилгажээ шторк<br>4. Албан тушаалтны ХОМ-тэй танилцах, мэдээлэл өгөх тухай шторк<br>5. Залуучуудаа авлигын эсрэг аянд нэгдэцгээе,<br>6. ТОВШ аппликэйшныг санал болгоё, Авлигын эсрэг хамтдаа шторк<br>7. Үгүй гэж хэлээд өөрчилье. Авлига ашиг сонирхлыг мэдээлэх тухай шторкыг 06 сарын 13-ны өдөр<br>8. Иргэн танд төрийн үйлчилгээ авахад хүндрэлтэй байна уу шторкыг 08 сарын 17-ны өдөр<br>9. Авлигын эсрэг нэгдье зургийг 08 сарын 08-ны өдөр фэйж хуудасын ковер болгосон.<br>10. Тэгш эрхийхээ төлөө хамтдаа, авлигад идэгдэхгүйгээр өөрсдөө хичээл зүтгэлээрээ | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | амжилтад хүрэхийг уриалж байна шторкыг 09 сарын 11-ны өдөр<br>11. Авлигыг мэдээлэх тухай богино хэмжээний бичлэгүүдийг 10 сарын 23, 31, 11 сарын 20, 22, 23, 27-ны өдрүүдэд<br>12. Үнэнч шударга байх тухай, зөвд зөв шударга зөв шторкыг 12 сарын 06-ны өдөр байгууллагын фэйсбүүк хуудсаар дамжуулан ажилтан албан хаагч, иргэн, олон нийтэд түгээн ажиллалаа.<br>Баримтжуулсан үр дүнгээр шторк бичлэгийг давхардсан тоогоор 984 хүн үзэж, 32 шэйр хийж, 78 лайк авсан байна.<br>"Авлигаас ангид төрийн үйлчилгээг хүргэе" уриан дор байгууллагын 150 албан хаагч нэгдсэн.<br>Мөн Авлигын эсрэг стикер наалтуудыг хаалга, ариун цэврийн өрөөнд нааж урдьчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлсэн. | |
| | | 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын | 2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён | Жилдээ | - | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан 2023 оны 05 сарын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | онцлогт тохируулан зохион байгуулах | гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх<br>Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх. | | | | 01-ний өдрөөс 06 сарын 01-ний өдөр хүртэл 1 сарын хугацаатай “Би өгөхгүй, авахгүй” нөлөөллийн аяныг Нийслэлийн Засаг захиргааны I,II,III,IV,Va,Vбв, Нийслэлийн Төр захиргааны цогцолбор байр, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв Драгон, Дүнжингарав, Мишээл салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төвийн 12 байршилд зохион байгуулсан.<br>Аяны хүрээнд байгууллагын нийт 274 албан хаагчдад авлигын хор уршиг, сөрөг нөлөөлөл мөн урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг зохион байгуулж, мэдээ мэдээллээр хангасан. Мөн тухайн байруудад үйл ажиллагаа явуулж буй Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн алба хаагчид, үйлчилгээ авч буй иргэдэд Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах зорилготойгоор авлигын эсрэг гарын авлага, сурталчилгааны зурагт хуудас, бусад материалуудыг тараах ажлыг зохион байгуулсан.<br>• Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн албан хаагчдын дунд 2023 оны 10 сарын 20-ны өдөр Авлигын эсрэг хууль, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | НАНБХАСЗАСЗУСтХ-ийн хүрээнд АХА тэмцээнийг зохион байгуулсан.<br>• Алба хаагчдын Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэхээр 2023 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр НҮНТ-Мишээл салбарын 2 ажилтанд, 11 дүгээр сарын 29-ний өдөр Сэлбэ дэд төвийн 9 ажилтанд, 11 дүгээр сарын 30-ний өдөр НЗЗ-ны II дугаар байрны 14 алба ажилтанд сургалтыг тус тус зохион байгуулсан.<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн хүрээнд НЗЗ-ны I, III байруудын албан хаагчдын дунд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | "Алтан хонх" танин мэдэхүйн тэмцээнийг 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан.<br>• НЗДТГ-аас зохион байгуулагдсан "Мэдье, нэгдье" аяны хүрээнд 2023 оны 11 дүгээр сард Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдэд "Авлигыг таслан зогсооход хүн бүрийн оролцоо чухал" сэдэвт асуулт хариултын тэмцээн, НЗЗ-ны IV, V байруудад Авлигын эсрэг хуулийн 16,17,18 дугаар зүйлийн хүрээд танин мэдэхүйн "Аха" тэмцээнийг, НҮНТ Мишээл, Дүнжингарав салбаруудад ашиг сонирхлын зөрчил гэж чухам юу болохыг, ашиг сонирхлын зөрчил хэрхэн илэрдэг, ашиг сонирхлын зөрчлийн үр дагавар, авлигыг мэдээлэх үүрэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулан ажиллав. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах | Мэдээллийг сар бүр шинэчлэх Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх. | Сар бүр | - | Байгууллагад “Шударга ёс хөгжил дэвшилд 110” самбарыг байршуулан мэдээллийг сар бүр шинэчлэн тайлант хугацаанд 12 удаа шинэчлэн ажилласан байна. Мөн НЗЗ-ны нийт 10 байршил дахь байгууллагын мэдээллийн самбарт авлигын эсрэг мэдээллийн буланг тогтмол ажиллуулж байна. | 100% |
| | | 1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх. | Сурталчилгааны материал боловсруулсан байх Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх Авлигыг мэдээлэх 110 | Жилдээ | - | 1. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн сурталчилгааг хийх зорилгоор “Авлигын эсрэг би авахгүй өгөхгүй” хөөсөн хүрээ (frame), уриалга бүхий 3 ширхэг хөөсөн хэвлэл, авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн сурталчилгааны материалд Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулан олон нийтэд хүргэсэн байна.<br>2. Нийслэлийн Засаг Захиргааны II байрны алба хаагчид, үйлчлүүлж буй иргэд авлигын эсрэг хүрээ (frame)-г уриалга болгон зураг авхуулах боломжийг бүрдүүлсэн.<br>3. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Чиглэл хүргүүлэх тухай 2023 оны 05 сарын 15-ны өдрийн 03/2996 дугаартай албан бичгийн дагуу “Иргэн танд” хуудсанд байгууллагын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дугаарыг оруулсан байх. | | | мэдээллийн оруулан шинэчилсэн.<br><br>4. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр “Авлигын эсрэг нэгдье” уриатай номын хавчаарыг хийж Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн алба хаагчдад олгосон. | |
| 2 | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | 2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх | Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх<br>Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | - | 1. Авлигатай тэмцэх газраас 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр ХАСХОМ мэдүүлэх үүрэгтэй мэдүүлэг гаргагчдад зориулсан сургалтад байгууллагын мэдүүлэг гаргах үүрэгтэй 10 албан хаагчийг хамруулсан.<br>2. Авлигатай тэмцэх газраас 2023 оны 04 сарын 24-ний өдөр шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 2 албан хаагч хамрагдсан.<br>3. Авлигатай тэмцэх газраас 2023 оны 05 сарын 29-ний Эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтад байгууллагын ЭБАТ хамрагдсан.<br><br>4. Авлигатай тэмцэх газраас 2023 оны 11 сарын 22-ны өдөр шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 2 албан хаагч хамрагдсан.<br>5. Газрын даргын 2023 оны 10 сарын 31-ний өдрийн А/52 дугаар тушаалаар Төрийн албан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу байгууллагын ёс зүйн дэд хороог байгуулж, ажиллах дүрмийг батлуулан байгууллагын 260 албан хаагчдад танилцуулсан.<br>Авлигатай тэмцэх газраас 2023 оны 12 дугаар сарын 14 өдөр зохион байгуулсан Авлигын эсрэг сургалтад 22 албан хаагч хамрагдсан. | |
| | | 2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах | Өөрсдийн нөөц боломцоонд тулгуурлан зохион байгуулсан байх<br>Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | - | Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын ажилтан албан хаагчид, Нийслэлийн Засаг Захиргааны байруудад үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага, иргэдэд авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах зорилготойгоор авлигын эсрэг гарын авлага, сурталчилгааны зурагт хуудас, бусад материалуудыг тараах ажлыг зохион байгуулан ажилласан. | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | арга хэмжээг зохион байгуулах. | | | | | |
| 3 | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | 3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх | Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | - | Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газарт бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд ажиллаж буй алба хаагчид ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг албан тушаалтнаас авч ажиллаж байгаа бөгөөд байгууллагыг төлөөлөн гэрээ байгуулж буй албан тушаалтнууд гэрээ байгуулахын өмнө Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан мэдэгдлийн дагуу 4 албан хаагч ашиг сонирхлын зөрчилгүй тухай 19 мэдэгдлийг гаргасан | 100% |
| | | 3.2."Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх | Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх Сургалт, мэдээлэл авсан байх | Жилдээ | - | Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээлэл үйл ажиллагааны ил тод байдал, Хүний нөөцийн ил тод байдал, төсөв санхүү, хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний мэдээллийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх. | | | www.khangardi.mn сайтын "ИЛ ТОД БАЙДАЛ" цэс болон мэдээллийн самбарт цахим болон цаасан суурьтайгаар байршуулан ажиллаж байна. Үүнд өөрийн чиг үүрэг, стратеги зохион байгуулалттай холбоотой 14 төрлийн мэдээллийг, Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийн хянаж, үнэлэх журам, холбогдох бусад 12 төрлийн тайлан мэдээг, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах үүднээс заасан хугацаанд тухай бүр тайлан, мэдээг гаргаж www.shilendans.gov.mn, тайлагнасан. | |
| **ШИЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 4 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ) | Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлох ажлыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх Тайланд нотломжийг | 3 дугаар улирал | - | Тус судалгааг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх төсөв байгууллагын төсөвт суугдаагүй тул хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.3.2. дахь заалтад заасны дагуу үнэлсэн. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хавсаргасан байх | | | | |
| | | 4.2.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх | 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байх Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх Тайланд нотломжийг хавсаргасан байх | 3 дугаар улирал | - | Хүнд суртлыг бууруулах зорилгоор 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Захиргаа, төлөвлөлт санхүүгийн хэлтсийн алба хаагчдын дунд хэлэлцүүлгийг зохион байгуулсан бол авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр Сэлбэ дэд төвд 8 албан хаагчийг хамруулан "Авлигыг таслан зогсооход хүн бүрийн оролцоо чухал" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. | 100% |
| | | 4.3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах. | Судалгааг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагууда д хүргүүлсэн байх Бодитой үр дүнг тооцсон байх Тайланд нотломжийг хавсаргасан байх | 3 дугаар улирал | - | Тус судалгааг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх төсөв байгууллагын төсөвт суугдаагүй.<br><br>Байгууллага дотооддоо хяналт, шалгалт хийж байр хариуцсан менежерийн ёс зүй, харилцаа хандлагын үнэлгээний талаар хийсэн судалгааны 10 дугаар асуулгад Ашиг сонирхлоос ангид байдлыг тусгасан ба судалгааны үр дүнд ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай зөрчил гараагүй болно.<br><br>(хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол "Бодлогын баримт бичгийн | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.3.2. дахь заалтад заасны дагуу үнэлсэн болно.) | |
| 5 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах | Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх<br>Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх<br>Арга хэмжээнд удирдлагын<br>Тайланд нотломжийг хавсаргасан байх. | 1 дүгээр улирал | - | 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 02 сарын 20-ны өдөр батлуулсан. Эхний хагас жилийн хэрэгжилтийг Захиргаа, төлөвлөлт санхүүгийн хэлтсийн албан хаагчдад танилцуулсан.<br>Жилийн эцсийн биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр байгууллагын тайлангийн хурал дээр танилцуулахаар бэлтгэл ажлыг бүрэн хангасан. | 100% |
| | | 5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд санал, зөвлөмжийг тусгасан байх | Санал тусгасан байх<br>Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | - | Тайлант хугацаанд санал өгөх төсөл байгууллагад ирээгүй болно. Авлигатай тэмцэх газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн "Маягт батлах тухай" А/31 тушаалаар нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг, мэдэгдэл тайлбарыг болон бусад холбогдох бүртгэлийн маягтыг шинэчлэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баталсан бөгөөд дээрх тушаалыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | |
| | | 5.3 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх Дүгнэлт зөвлөмж гаргасан байх | 4 дүгээр улирал | - | Газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 16-ний өдөр баталсан 06 дугаар удирдамжийн дагуу Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байр, Нийслэлийн Засаг захиргааны I, II, III, IV, V байр, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн Драгон, Мишээл, Дунжингарав салбар, Сэлбэ, Баянхошуу дэд төвийн өдөр тутмын үйл ажиллагаа, цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан “Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалт хийн дүгнэлт гаргаж зөвлөмж хүргүүлсэн. | 100% |
| | | 5.4 Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулах | Эх үүсвэрийн тоог нэмэгдүүлж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг сайжруулсан байх. | Жилдээ | - | Өргөдөл гомдлыг нийт 11 сувгаар хүлээн авч байгаа бөгөөд тайлант хугацаанд нийт 115 өргөдөл ирснийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем www.erp.ulaanbaatar.mn сайтад бүртгэн 219 өргөдлийг бүрэн шийдвэрлэж хариуг танилцуулсан. Мөн хугацаанд | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өргөдөл гомдлын бүртгэл, явц болон шийдвэрлэхтэй холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 10 цаг 44 минут байгаа нь 2022 оны мөн үеийхээс буурсан үзүүлэлттэй байна. | |
| | | 5.5 Байгууллагын удирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэл, хэрэгжилтийг сайжруулах | Ажлын хэсэг болон албан тушаалтанд даалгасан тушаалын хэрэгжилт үр дүнг тооцсон байх Тушаал шийдвэрийн үндэслэлийг хуулийн дагуу боловсруулсан байх | Жилдээ | - | Тайлант хугацаанд эрх бүхий албан тушаалтан хуулийн дагуу тушаалын төслийг боловсруулан газрын даргын А тушаал 54, Б тушаал 357 гаргасан байна. | 100% |
| | | 5.6 Худалдан авах ажиллагааг сайжруулах чиглэлээр А3 сургалтад хамрагдах албан хаагчийн тоог нэмэгдүүлэх | 10 албан хаагчийг хамруулсан байх | Жилдээ | - | Захиргаа төлөвлөлт санхүүгийн хэлтэс, Үйлдвэрлэл үйлчилгээний албаны нийт 10 албан хаагч 2023 оны 11 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд Засгийн газрын худалдан авах ажиллагааны А3 сургалтад хамрагдаж худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээг 6 албан хаагч авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Байгууллын хэмжээнд нийт 13 албан хаагч А3 гэрчилгээтэй байна. | |
| | | 5.7 Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах | Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр ажил зохион байгуулсан байх<br>Төрийн хэмнэлтийн тухай болон Төсвийн тухай хуулиудыг хэрэгжилтийг хангасан байх | Жилдээ | - | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн Хоёрдугаар бүлэг хангамж, зарим үйл ажиллагаанд тавих хязгаарлалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан. Тайлант хугацаанд гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны 912,942,800 төгрөгийн хэмнэлтийг, тээвэр, шатахуунд тухайн төсвийн 10 хувийг хэмнэж ажилласан. | 100% |
| | | 5.8 Нийслэл, дүүргийн төрийн албан хаагч нарт ёс зүйн сургалт зохион байгуулах | Төлөвлөгөөт сургалтыг зохион байгуулж, албан хаагч нарыг хамруулсан байх. | Жилдээ | - | Нийслэлийн Засаг захиргааны 2 байр Хангарди ордонд 2023.05.12-ны өдөр зохион байгуулагдсан Удирдлагын ажилтны ёс зүй сургалтад ЗТСХ-ийн 4 албан хаагч хамрагдсан.<br>Хүний нөөцийн хөгжлийн төвөөс 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй" сургалтад 3 албан хаагч амжилттай хамрагдсан. | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ШҮҮР АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| | | 5.11 Нийтийн албанд танилын хүрээгээр томилогдохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх | Төрийн албаны тухай хууль, журмын хэрэгжилтийг хангасан байх | Жилдээ | - | Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заасан ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан томилон ажиллаж байна. ХАСУМ мэдүүлэх шаардлагатай албан тушаалд Авлигатай тэмцэх газраас ирсэн албан бичгийн дагуу томилгоог хийн ажилласан. | 100% |
| | | 5.12 Авлига, албан тушаалын гэмт хэргийн хариуцлага гарцаагүй байх, холбогдсон этгээдийг нийтийн албанаас шүүрдэн цэвэрлэх | Холбогдох хууль журмыг зөрчин томилогдсон албан хаагчдыг чөлөөлөх | 1, 2 дугаар улирал | - | Албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлагын мэргэжлийн болон боловсролын түвшинг хангахгүй нийт 3 албан хаагчийг эрхэлж буй албан тушаалаас чөлөөлж, албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлага хангаж буй сул орон тоонд албан тушаал бууруулан шилжүүлэн томилсон. | 100% |

ТАЙЛАН ХЯНАСАН:
ЗАХИРГАА ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР Б.ЗОЛБАЯР

ТАЙЛАН НЭГТГЭН ГАРГАСАН:
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН Ю.ХҮСЛЭН